



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/174

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг хавсралтад заагдсан сумын Засаг дарга, байгууллагын дарга нарт олгосугай.

2. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, гэрээ байгуулан хүлээн авахыг хавсралтад заагдсан сумын Засаг дарга, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай.

4. Хавсралтад тусгагдсан төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
03 дугаар сарын 26-ны ний өдрийн 4/124 дүгээр
захирамжийн хавсралт

Д/Д	Төсөл арга хэмжээний нэр	Нийт төсөвт өртөг /мян.төг/	Тухайн онд санхүүжүүлэх төсөвт өртөг /мян.төг/	ХАА-нд мөрдөх журам	Тайлан мэдээ ирүүлэх хугацаа	Эрх шилжүүлсэн сумдын Засаг дарга, байгууллагын дарга
1	2	3	4	5	6	7
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ						
1	Төрийн албаны Булган аймаг дахь салбар зөвлөлийн техник, тоног төхөөрөмж	50,000.00	50,000.00	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Аймгийн ЗДТГ- ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Наранбаяр
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ						
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	40,000.00	40,000.00	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Аймгийн ЗДТГ- ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Наранбаяр
Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ						
1	Сумын төвийн замын ажил (Бүрэгхангай сум)	250,000.00	250,000.00	НТШ	Сар бүрийн 25-ны өдөр	Бүрэгхангай сумын Засаг дарга Э.Эрдэнэбулган
Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ						
1	Цэвэр усны нөөцийг хамгаалах зорилгоор шугам хоолойг хлоржуулах төхөөрөмжийн засвар хийж, тоноглол солих (Булган сум)	140,000.00	140,000.00	НТШ	Сар бүрийн 25-ны өдөр	"Булган Мээж" ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Ганбаатар
НИЙТ ДҮН		480,000.0	480,000.0			